



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 6/27

Чингис хот

Ж.Ганбаатарыг мөнгөн шагналаар
шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.1, 58.2.20 дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/87 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын шагнал олгох журам”-ын 5.6, 2020 оны А/32 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Ганбаатар “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнагдсан тул 100000 /нэг зуун мянган/ төгрөгийн мөнгөн шагналаар шагнасугай.

2. Шагналыг байгууллагын холбогдох зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Э.Ариунтунгалаг/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА